# АЙМГИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭСЭЭС ИРҮҮЛСЭН АЛБАН ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭХДЭЭ АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС АНГИД ХУУЛИЙН ХҮРЭЭНД ШУДАРГА ШИЙДВЭР ГАРГАЖ АЖИЛЛАХ ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2024 оны 06 дугаар сарын 10 Залаа

| № | Өгсөн зөвлөмж | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Зөвлөмж 1: Нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж бичгээр мэдэгдэх, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар гаргаж хэвшүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах | 1.1. Нийтийн албан тушаалтны хөрөнгө орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хураангуй хэлбэрээр мэдээлэх | Зөрчил гаргалгүй ажиллах | 100 | 100 | Төсөвт байгууллагуудын дарга, эрхлэгч, захирал, нягтлан бодогчид, санхүүгийн албаны дарга, төсөв төрийн сангийн мэргэжилтэн зэрэг 12 албан тушаалтны 2023 оны ХАСХОМ-ийн өөрчлөлтийг 2024 оны 02 дугаар сарын 13-ны дотор баталгаажуулж ажиллалаа. |
| | | 1.2. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар иргэдэд мэдээлэл өгөх журмын талаар мэдээлэл, зөвлөгөөн хийх | Мэдээл-лийн тоо 1 Хамрагдсан албан хаагчид 11 | 100 | 100 | ХАСХОМ тайлагналтын талаар Тамгын газрын дарга 2024 оны 01 сард Төсөвт байгууллагуудын дарга, эрхлэгч, захирал, нягтлан бодогчид, санхүүгийн албаны дарга, төсөв төрийн сангийн мэргэжилтэн нарт мэдээлэл хийж, ХАСХОМ-ыг бөглүүлсэн. |
| 2 | Зөвлөмж 2: Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж өөртөө, бусдад давуу байдал бий болгосон хууль бус үйлдэл гаргахгүй байх | Эрүүгийн тухай хуулийн талаар сургалт зохион байгуулах | Сургалтын тоо 2 | 100 | 100 | Гэмт хэрг зөрчлөөс ангид байх хүрээнд цагдаагийн ахлах ахлагч Д.Балжинням Эрүүгийн тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаарх сургалтыг 04 дүгээр сарын 14-ний өдөр Мэдээллийн цагаар 22 иргэд, 66 төрийн албан хаагчид орсон. Албан хаагч нараас авлигын гэмт хэрэгт холбогдсон тохиолдол бүртгэгдээгүй байна. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | Зөвлөмж 3: Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд байгууллага бүр шударга ёсыг бэхжүүлэх замаар ил тод байдал, хяналт хариуцлагыг сайжруулж, хуулийн хүрээнд шийдвэр гарган үйл ажиллагаагаа удирдан зохион байгуулах | 3.1.Авлигад өртөж болзошгүй ажлын байрны судалгааг гаргах | Судалгаа гаргах | 0 | 100 | Хүлээгдэж байна. Хэрхэн судалгааг гаргах талаар ойлголт байсангүй. |
| | | 3.2.Авлигын эсрэг баталгааны маягтыг албан хаагчдаар бөглүүлж, хувийн хэрэгт хийх | Баталгааны маягт бөглөсөн албан хаагчдын тоо - 35 | 0 | 100 | Засаг даргын Тамгын газрын албан хаагчид "Авлигын асрэг гэрэл түгээе" уриалга бүхий энгэрийн тэмдэгийг бэлтгэн ажлын байран дээрээ зүүж байна. Мөн Тамгын газрын бүх албан хаагчид аяны хүрээнд Авлигын эсрэг баталгааны маягтыг гарган, гарын үсэг зурж хувийн хэрэгтээ хийж ажиллалаа. |
| 4 | Зөвлөмж 4: Төрийн албаны тухай хуульд заасан ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх үүргийг гүйцэтгэж нийцүүлэхгүй байхад анхаарч шударга бус, ёс зүйгүй үйлдлийг нэн даруй таслан зогсоох арга хэмжээ авах | 4.1.Сургалт сурталчилгааг зохион байгуулах | Сургалтын тоо- 2 Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо - 35 | 0 | 100 | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухайн хуулийн талаар нийт албан хаагчдад 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулж сурталчлан ажиллалаа. Мөн 03 дугаар сарын 26-ны өдөр ёс зүйн тухайн хууль болон байгууллагын соёл сэдвээр нийт 25 албан хаагчдад сургалт зөвлөгөөнийг өгч ажиллалаа. |
| 5 | Зөвлөмж 5: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг нийт албан хаагчдад танилцуулж, сурталчлан нөлөөллийн олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулан ирээдүйд бий болох эрсдэлийг бууруулах | 5.1.Төрийн албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан танилцуулах | Сургалтын тоо- 4 Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо - 60 | 0 | 100 | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухайн хуулийн талаар нийт албан хаагчдад 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулж сурталчлан ажиллалаа. Мөн 03 дугаар сарын 26-ны өдөр ёс зүйн тухайн хууль болон байгууллагын соёл сэдвээр нийт 25 албан хаагчдад сургалт зөвлөгөөнийг өгч ажиллалаа. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | Зөвлөмж 6: Нийтийн албан хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг, шан харамж буюу тодорхой үнэ шингэсэн зүйлийг авах, хувь тохиргоо хийх, өөрт ашигтай байдлыг бий болгож амлалт өгөх зэрэг хориглолтыг зөрчихгүй байх | 6.1.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар мэдээлэл бэлтгэн төрийн албан хаагчдад сургалт хийх | Сургалтын тоо -2 Сургалтад хамрагдсан иргэдийн тоо - 60 | 0 | 100 | Гэмт хэрг зөрчлөөс ангид байх хүрээнд цагдаагийн ахлах ахлагч Д.Балжинням Эрүүгийн тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаарх сургалтыг 04 дүгээр сарын 14-ний өдөр Мэдээллийн цагаар 22 иргэд, 66 төрийн албан хаагчид орсон. Албан хаагч нараас авлигын гэмт хэрэгт холбогдсон тохиолдол бүртгэгдээгүй байна. |
| 7 | Зөвлөмж 7: Нийтийн албан тушаалтан нь албаны бүрэн эрхээ хэрэгжүүлж үнэн зөв шийдвэр гаргахтай холбоотойгоор хөндлөнгийн хууль бус нөлөөнд автахгүй байж энэ талаар /Удирдах албан тушаалтан, Авлигатай тэмцэх газрын “110” тусгай дугаарт/ нэн даруй мэдэгдэх | 7.1.Авлигын талаарх сургалт болон холбогдох гарын авлагыг байгууллагын албан ёсны цахим хуудсаар байршуулж, сурталчилах | Гарын авлагын тоо – 200 Цахим хуудасны хандалтын тоо | 0 | 100 | Авлигатай тэмцэх газрын албан ёсны цахим хуудсыг Шинэжинст ЗДТГ, shinejinst shinejinst байгууллагын албан ёсны цахим хуудсуудаар дагаж, өдөр бүр нэвтэрч холбогдох мэдээллийг шэйр хийж олон нийтэд хүргэж ажиллалаа. Гомдол, мэдээлэл хүлээн авах 110 утасны постерыг ашиглан авлигатай тэмцэх газрын албан ёсны фэйж, өргөдөл гомдол хүлээн авах 1111 төв, irgen.bayankhongor.gov.mn сайтыг сурталчлан 04 дүгээр сарын 15-ний өдрийн мэдээллийн цагаар 61 төрийн албан хаагч, 22 иргэнд сургалт орсон. Үндсэн хууль батлагдсаны 100 жил, ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 32 жилийн ой, авлигын эсрэг хууль, Татварын тухай хуулийн талаар АХА тэмцээнийг Авто тээврийн үзлэгийн өдөр буюу 05 дугаар сарын 07-нд |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийт 50 иргэдийн дунд зохион байгуулсан, Эхний 3 байрыг шалгаруулж, шагналд авлигаас ангид байх номыг гардуулж өгөв. Мэн энэ үеэр холбогдох 100 гарын авлагыг иргэдэд хэвлэн тарааж өгөв. |
| | | 7.2.Сургуулийн сурагчдын дунд авлигын хор уршигийн талаар сурталчилж, Уралдаан зарлаж идэвхжүүлэх | Сургалтын тоо - 2 | 0 | 100 | Сургуулийн сурагчдын дунд авлига, шударга ёсны ойлголтын талаар Нийгмийн багш Ж.Гэрэлтуяатай хамтран хичээлийн цагаар мэдээлэл өгч, мөн нэг удаагийн богино бичлэг хийж сумын албан ёсны сайт Шинэжинст ЗДТГ группэд байршуулж ажиллалаа. 9 ангийн 2 бүлгийн 23 хүүхдүүдийн дунд “Авлига гэж юу вэ?” гэсэн шторк хийлгэж, нийт 12 сурагч авлигын талаарх бичлэг хийсэн. Бичлэг хийсэн сурагчиддаа зохих хэмжээний дүнгийн урамшууллыг өгч ажилласан байна. |
| 8 | Зөвлөмж 8: Байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан хаагчдаас авлигыг үл тэвчих, ёс зүйтэй байх, шударга ёсыг эрхэмлэн ажиллах баталгаа гаргуулах | 8.1.Албан хаагчдаас авлигыг үл тэвчих, ёс зүйтэй байх, шударга ёсыг эрхэмлэн ажиллах баталгааны маягтыг албан хаагчдаар бөглүүлж, хувийн хэрэгт хийх | Баталгаа гаргасан албан хаагчдын тоо - 35 | 0 | 100 | Засаг даргын Тамгын газрын албан хаагчид “Авлигын асрэг гэрэл түгээе” уриалга бүхий энгэрийн тэмдэгийг бэлтгэн ажлын байран дээрээ зүүж байна. Мөн Тамгын газрын бүх албан хаагчид аяны хүрээнд Авлигын эсрэг баталгааны маягтыг гарган, гарын үсэг зурж хувийн хэрэгтээ хийж ажиллалаа. |

ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.БАТХУЯГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Г.БАТЧИМЭГ